- Нийгмийн даатгалын тухай хууль

- Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар баталсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”
- Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/226 дугаар тушаалаар баталсан “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Гаалийн тухай хууль 3 удаа,
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд 2 удаа тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 4-р хавсралтаар “Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”, 10-р хавсралтаар “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ”-г шинэчлэн тогтоосон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Орхон аймаг дахь Гаалийн газарт дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан байхгүй байна. Дотоод аудитын чиг үүргийг ГЕГ-ын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар ГЕГ-ын даргын 2019 оны А/298 дугаар тушаалаар баталсан “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал”-ын дагуу хэрэгжүүлдэг байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймаг дахь Гаалийн газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/272 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг системийн хэмжээнд мөрдөж байгаа бөгөөд уг баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Орхон аймаг дахь Гаалийн газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 429,568.4 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	6,209.4	6,209.4
Бараа материал	133,252.0	150,001.8	16,749.8
Үндсэн хөрөнгө	5,377,629.4	4,925,101.8	-452,527.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,510,881.4</b>	<b>5,081,313.0</b>	<b>-429,568.4</b>
Өр төлбөр	3.0	0.0	-3.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,510,878.4	5,081,313.0	-429,565.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>5,510,881.4</b>	<b>5,081,313.0</b>	<b>-429,568.4</b>

Авлагын дансны өсөлт нь тайлант онд НДШ-ийн болон цалин хөлсний ХХОАТ-н авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын данс өмнөх оноос 16,749.8 мянган төгрөгөөр өссөн ч үндсэн хөрөнгийн данс 452,527.6 мянган төгрөгөөр буурсан тул нийт хөрөнгийг бууруулсан байна. Бараа материалын дансны өсөлт нь малын нас нэмэлт, төл авалттай холбоотой бол, үндсэн хөрөнгийн дансны бууралт нь тайлант оны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Газрын даргын 2023 оны А/25 дугаар тушаалаар оны эцэст тооллогын комисс болон өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн 1,860.0 мянган төгрөгийн 16 толгой малыг заазалж данс бүртгэлээс хассан, мал олгох зөвшөөрлийн хуудсаар 1,560.0 мянган төгрөгийн 14 толгой малыг зарцуулсан байна.

Тайлант онд Гаалийн салбар лабораторийн 105,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий 500 м.кв газрыг Төрийн байгууллагын газар эзэмших гэрчилгээ, газрын цахим системийн бүртгэлийг үндэслэн үндсэн хөрөнгөд бүртгэсэн, орон нутгийн төсвийн 111,202.7 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийсэн байгууллагын гаднах асфальтан зам, талбайг тохижилтын ажил, ГЕГ-аас ирсэн 105,060.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг мөн үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна. Үндсэн болон нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан 41,820.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдаж авсан байна.

ТӨБЗГ-ын 2023 оны 684 дүгээр тогтоолыг үндэслэн газрын даргын тушаалаар ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн 31 нэр төрлийн 51,618.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо данс нь тайлант үеийн үр дүнгийн дансны нөлөөллөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,004,040.0 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 2,000.0 мянга, төгрөгөөр бүрдүүлж, нийт зарлагыг 1,006,040.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 151,396.4 мянган төгрөгөөр бууруулж 854,643.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор цалингийн зардал нэмэгдсэн бөгөөд тус байгууллагын тодотгосон төсвийн хуваариар нийт зардлыг 1,330,901.1 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэн байна.

Үүнд: Цалингийн зардал 293,900.0 мянга, НДШ-ийн зардал 43,487.5 мянга, хангамжийн зардал 3,600.0 мянга, нормативт зардал 2,520.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 64,000.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 13,510.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал 54,700.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,323,901.1 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 7,000.0 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр тодотгож баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 476,257.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70205 /Татвар хураалт, орлого бүрдүүлэлт/ хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,323,901.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, түрээсийн цэвэр орлогоор 1,386.4 мянган төгрөг олж, урсгал үйл ажиллагаанд 1,240,837.5 мянган төгрөгийг зарцуулж 84,450.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,240,837.5 мянган төгрөг буюу 93.2 хувьтай байгаа нь орон тооны хэмнэлтээс үүдэн цалин, НДШ-ын зардлыг 71,444.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,637.5 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 181.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,410.9 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 12,325.4 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Татвар хураалт, орлого бүрдүүлэлт	1,330,901.1	1,240,837.5	90,063.6	93.2
1.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,206,741.1	1,129,002.9	77,738.2	93.6
1.2	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	10,260.0	10,260.0	0.0	100.0
1.3	Харуул, хамгаалалтын зардал	57,600.0	57,600.0	0.0	100.0
1.4	Ажил олгогчоос олгох, тэтгэмж	56,300.0	43,974.6	12,325.4	78.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс эх үүсвэрийг шийдвэрлэсэн 12,398.0 мянган төгрөгийн гүйлгээ тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тусгайлан нэмэлтээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй болно.

#### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Орхон аймаг дахь Гаалийн газар нь харуул хамгаалалтын зардалд худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар цахимаар 2 удаа зохион байгуулж гүйцэтгэгчийг шалгаруулж гэрээ байгуулан ажиллаж байна.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс санхүүжилтийг шийдвэрлүүлж 12,398.0 мянган төгрөгөөр 2023 оны 4-р сард ухаалаг дэлгэц нэмэлт санхүүжилтийн дансаараа дамжуулан худалдан авсан, мөн 2023 оны 12 дугаар сарын төсвийн хуваарийг нэмэгдүүлэн баталж 2 аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулан нийт 25,800.0 мянган төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулахад зарцуулсан байна.

Батлагдсан төсвийн хүрээнд урсгал зардлуудын худалдан авалтыг тухай бүр шууд гэрээ байгуулан худалдан авч, гэрээ дүгнэсэн акт үйлдэж хүлээн авч ажиллаж байна.



## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймаг дахь Гаалийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Оргилмөрөн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймаг дахь Гаалийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 01/11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн дүнгүүд нь харилцан адилгүй буюу хөрөнгийн дүн харьцангуй өндөр, нийт орлого нь тухайн онд хүлээн авсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоос хамаарч хэлбэлздэг бөгөөд төсвийн байгууллага нь батлагдсан төсвийн хүрээнд зардлын ангиллаар зарцуулалт хийдэг тул материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн 1,330,901.1 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 26,618.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Орхон аймаг дахь Гаалийн газар нь гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалт хийх болон ажилчдыг зөөх зориулалттай 3 автомашин ашиглаж байна. Эдгээрийн жилийн шатахууны зардал нь 12,000.0 мянган төгрөг байна.

Батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд 2 жолооч ажилладаг бөгөөд жилийн цалингийн зардал нь 26,337.9 мянган төгрөг байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой тогтмол зардлыг хэмнэж ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,273,159.1 мянган төгрөгийн 14 орлогын гүйлгээнээс 66,398.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 144,130.1 мянган төгрөгийн зарлагын 8 гүйлгээнээс 7,160.7 мянган төгрөгийн 1 гүйлгээг тус тус дутуу мэдээлсэн

Мөн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулбал зохих 159 талбарын мэдээллээс хугацаандаа оруулсан 153 талбарын мэдээлэл, хугацаа хоцроосон 1 талбарын мэдээлэл, хугацаа болоогүй буюу 5 талбарын мэдээлэл байна. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Орхон аймаг дахь Гаалийн газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж асуудлын бүртгэл хүргүүлсэн бөгөөд асуудлын бүртгэлээр өгсөн алдаа, зөрчилтэй асуудлыг залруулж ажилласан байна.

Завсрын аудитаар өгсөн алдаа, зөрчилтэй асуудлын хэрэгжилтийг хангаж ажилласан тул залруулсан алдаагаар үнэлж аудитын тайлангийн 5 дугаар бүлгийн залруулсан алдааны хэсэгт дэлгэрэнгүй тусгав.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	21,930.0	1	21,930.0	100.0%
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>21,930.0</b>	<b>1</b>	<b>21,930.0</b>	<b>100.0%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймаг дахь Гаалийн газрын санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар бараа материал дансыг авч үзэж болох юм.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,613.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 6,613.2 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Тайлант оны эцэст ХХОАТ-т илүү шилжүүлсэн нийт 5,013,069.96 төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай нийцэхгүй байна.
- Завсрын аудитаар өгсөн дараах асуудлуудын хэрэгжилтийг хангасан байна.

1. Хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд газрын даргын тушаалаар урт хугацааны буюу ажлын 22 хүртэлх хоногоор цалинтай чөлөө олгосон 3 албан хаагчийн цалинтай чөлөөтэй байх хугацааны цалинд хоолны мөнгө болон холбогдох бүх нэмэгдлийг оруулж тооцсоноор цалинг 1,600,106.36 төгрөгөөр илүү олгосон нь байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Холбогдох албан хаагчдын 2023 оны 12-р сарын цалингаас илүү олгосон цалинг буцаан суутгаж алдаа, зөрчлийг залруулж ажилласан байна.

2. Бараа материалын тайланд шаардах хуудаснаас гадна худалдан борлуулагчийн төлбөрийн баримт, харилцахын төлбөрийн хүсэлт, санхүүгийн программаас зарлагын баримт тус тус хэвлэж хавсаргаж бичиг хэргийн зардлыг үргүй зарцуулж байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.4-д "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3. Шатахууны төлбөрийн баримт худалдан авалтын төлбөрийн хүсэлтийн дүнтэй нийцэхгүй, сарын шатахууны зардлын төсвийн хуваарийн нийт дүнгээр тохируулан худалдан авалт хийж, жолоочийн тооцооны хуудасны нийт бөөн дүнгээр зардал гаргаж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 16,081.7 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 1,593.8.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 14,487.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

1. Хүүхэд асрах чөлөөнөөс 2023 оны 6-р сард ажилдаа эргэж орж ирсэн албан хаагчид 2023 оны 12-р сард ээлжийн амралтаа биеэр эдлээгүй шалтгаанаар Орхон аймаг дахь Гаалийн газрын даргын 2023 оны Б/27 дугаар тушаалаар 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгохоор шийдвэрлэж нийт 1,593,797 төгрөгийн цалин илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.3-д "төсвийн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1-д “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. ...”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 2.1-д “Ажилтны ээлжийн амралтыг ажлын жилээр тооцно. Ээлжийн амралт олгох ажлын жил нь ажилтан хөдөлмөр эрхлэлтийн харилцаа анх үүсгэсэн өдрөөс эхлэн тооцогдоно”, 2.5-д “Хүүхэд асрах чөлөөтэй байсан, цэргийн жинхэнэ алба хаасан, 6 сараас дээш хугацаагаар сургалтад хамрагдсан, гэрч, хохирогчийн хамгаалалтад байсан, ажил үүрэг гүйцэтгэхийг эрх бүхий байгууллагаас түдгэлзүүлсэн хугацаанд ээлжийн амралт тооцож олгохгүй” гэж заасантай нийцэхгүй байна.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, цалингийн зардлыг хооронд нь болон оны эцэст бүх албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас /213209/ олгосон 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний шагналаас суутгасан ХХОАТ-н 4,630.4 мянган төгрөгийг цалингийн зардлаас /210101/ шилжүүлж зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, жилийн эцсийн хувь хүний орлогын албан татварын тайланг алдаатай бэлтгэж 84.0 мянган төгрөгийн, 2023 оны 08-р сарын НДШ-ийн тайланг алдаатай бэлтгэж 3,564.1 мянган төгрөгийн илүү зардал тус тус гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6-д “Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахгүй байж, НДШ-ийн болон ХХОАТ-ын тайланг бодогдсон цалингийн дүнтэй тулган, сайтар нягталж үнэн зөв бэлтгэж байх. НДШ-ийн 2023 оны 8-р сарын тайланг залруулах талаар НДХ-т хүсэлт гаргах шийдвэрлүүлэх.

### **2. Авлагын данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тус газрын НДШ-ийн болон санхүүгийн тайланд орсон залруулгатай холбоотойгоор тайлант онд нийт 6,209,403.53 төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэж заасантай нийцэхгүй байна

**Өгсөн зөвлөмж:** Санхүүгийн ажилтнуудын хариуцлагыг дээшлүүлж холбогдох авлага, өр төлбөрийг бүрэн хянаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд газрын даргын тушаалаар урт хугацааны буюу ажлын 22 хүртэлх хоногоор цалинтай чөлөө олгосон 3 албан хаагчийн цалинтай чөлөөтэй байх хугацааны цалинд хоолны мөнгө болон холбогдох бүх нэмэгдлийг оруулж тооцсоноор цалинг 1,600,106.36 төгрөгөөр илүү олгосон байна.	1	1,600.1			1	1,600.1	1	1,600.1				
Бараа материалын тайланд шаардах хуудаснаас гадна худалдан борлуулагчийн төлбөрийн баримт, харилцахын төлбөрийн хүсэлт, санхүүгийн программаас зарлагын баримт тус тус хэвлэж хавсаргаж бичиг хэргийн зардлыг үргүй зарцуулж байна.	1	0.0			1	0.0	1	0.0				
Шатахууны төлбөрийн баримт худалдан авалтын төлбөрийн хүсэлтийн дүнтэй нийцэхгүй, сарын шатахууны зардлын төсвийн хуваарийн нийт дүнгээр тохируулан худалдан авалт хийж, жолоочийн тооцооны хуудасны нийт бөөн дүнгээр зардал гаргаж байна.	1	0.0			1	0.0	1	0.0				
Тайлант оны эцэст ХХОАТ-т илүү шилжүүлсэн нийт 5,013,069.96 төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан байна.	1	5,013.1	1	5,013.1								
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>6,613.2</b>	<b>1</b>	<b>5,013.1</b>	<b>3</b>	<b>1,600.1</b>	<b>3</b>	<b>1,600.1</b>				

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус газрын НДШ-ийн болон санхүүгийн тайланд орсон залруулгатай холбоотойгоор тайлант онд нийт 6,209,403.53 төгрөгийн авлага үүсгэсэн байна.	1	6,209.4					1	6,209.4				
Хүүхэд асрах чөлөөнөөс 2023 оны 6-р сард ажилдаа эргэж орж ирсэн албан хаагчид 2023 оны 12-р сард ээлжийн амралтаа биеэр эдлээгүй шалтгаанаар Орхон аймаг дахь Гаалийн газрын даргын 2023 оны Б/27 дугаар тушаалаар 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгохоор шийдвэрлэж нийт 1,593,797 төгрөгийн цалин илүү олгосон байна.	1	1,593.8	1	1,593.8								
Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, цалингийн зардлыг хооронд нь болон оны эцэст бүх албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас /213209/ олгосон 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний шагналаас суутгасан ХХОАТ-н 4,630.4 мянган төгрөгийг цалингийн зардлаас /210101/ шилжүүлж зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, жилийн эцсийн хувь хүний орлогын албан татварын тайланг алдаатай бэлтгэж 84.0 мянган төгрөгийн, 2023 оны 08-р сарын НДШ-ийн тайланг алдаатай бэлтгэж 3,564.1 мянган төгрөгийн илүү зардал тус тус гаргасан байна.	1	8,278.5					1	8,278.5				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>16,081.7</b>	1	1,593.8			2	14,487.9				